



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

УЛААНБААТАР ХОТ  
2026 он

## ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Дархан уул аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тухай

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Авлигатай тэмцэх газраас 2026 оны 03 дугаар сарын 25-ны 05/5074 дүгээр “Хяналт шалгалт хийлгүүлэх тухай” албан бичгийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд иргэний гаргасан гомдолд дурдсан асуудлаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>2</sup> дугаар зүйлийн 5<sup>2.1</sup>, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1, 5.2, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг тус тус үндэслэн төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэв.

Санхүүгийн хяналт шалгалтыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, ахлах шинжээч Ц.Алтанхуяг, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын асуудал хариуцсан шинжээч Г.Шүрэндолгор нар гүйцэтгэв.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд дараах чиглэлээр санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэнэ. Үүнд:

2.1 Байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдын 2025 оны цалингийн сангийн зарцуулалт, ажлын цаг ашиглалтын талаар хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийн тухай

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 28 орон тоонд 949,132.2 мянган төгрөгийн цалин олгогдсоноос улсын төсвийн санхүүжилтээр 793,469.4 мянган төгрөгийн цалин хөлс болон нэмэгдэл цалин, орон нутгийн санхүүжилтээр 155,662.8 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдлийг тус тус олгосон байна.

эцсийн байдлаар 403,209.3 мянган төгрөгийн үндсэн цалин, 407,687.0 мянган төгрөгийн нэмэгдэл, 75,248.0 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлт, 58,141.8 мянган төгрөгийн урамшуулал тооцоологдон олгогдсон байна.

Тайлант 2025 оны жилийн эцсийн байдлаар Төрийн албаны тухай хуульд заасан нэмэгдэл, нэмэгдэл хөлс, хоол унааны хөнгөлөлт, ээлжийн амралтын олговрыг дараах эх үүсвэрээс олгосон байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл цалингийн задаргаа

Хүснэгт 1 /мянган төгрөг/

Үзүүлэлт	Орон нутгийн		Ур чадвар		Мэргэшлийн зэрэг		Зэрэг дэвийн		Албан хаасан хугацааны		Хоол унаа		Хавсран		Ээлжийн амралт	
	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо	Мөнгөн дүн	албан хаагчдын тоо
Улсын төсөв	89,841.4	28	52,232.2	14	2,550.7	1	4,459.6	2	41,056.3	23	75,248.0	28	4,846.0	2	61,884.0	6
Орон нутгийн төсөв	155,662.8	28														
Дүн	245,504.2	28	52,232.2	14	2,550.7	1	4,459.6	2	41,056.3	23	75,248.0	28	4,846.0	2	61,884.0	6
Нийт цалинд эзлэх хувь	25%		13%		3%		0.4%		4%		8%		0.5%		7%	

Орон нутгийн нэмэгдлийг улсын болон орон нутгийн төсвөөс нийт ажилтан, албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчдад олгогдох ур чадварын нэмэгдлийг 14 албан хаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 1 албан хаагч, төрийн захиргааны зэрэг дэвийн нэмэгдлийг 2 албан хаагчид тус тус олгож байна. Байгууллагын 2025 онд авсан цалин хөлс, нэмэгдэл цалин урамшууллын дэлгэрэнгүйг хавсралтаар гаргав.

Тус байгууллага нь хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ахмад настнуудад цагаан сараар хүндэтгэл үзүүлэх зардалд 2024 онд 960.0 мянган төгрөг, 2025 онд 1,800.0 мянган төгрөг, ажилтан албан хаагчдын ар гэрийн гачигдалд нэг удаагийн тэтгэмж 2024 онд 2 албан хаагчид нийт 1,000.0 төгрөгийг тус тус олгожээ. Байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны А/20 дугаар “Ахмадын сан” байгуулан холбогдох журам батлан ажиллуулж байгаа нь Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг тус тус хэрэгжүүлэн ажиллажээ.

Төрийн аудитаас 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй албан хаагчид 1 албан хаагчид үр дүнгийн урамшуулал 471.3 мянган төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Дээрх зөрчилд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1.7 дахь заалт “Хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага

харилцан хүлээн зөвшөөрөх” зарчмыг баримтлан тус зөрчилд давтан зөрчил өгөөгүй болно.

2.2 Байгууллагын 2024 онд тохиосон ойн арга хэмжээний төсөв, хандив тусламжийн хөрөнгийн бүрдүүлэлт, түүний зарцуулалтын тухай

### 2.2.1 Улс, орон нутгийн төсвийн зарцуулалт

Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар 2024 онд байгууллагынхаа үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх зөвшөөрлийг аймгийн Засаг дарга 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01-А/258 дугаар захирамжаар олгосон байна. Тус захирамжийн дагуу Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/31 дүгээр “Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай” тушаалыг гаргасан байна. Тушаалын нэгдүгээр хавсралтаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, хоёрдугаар хавсралтаар ажлын төлөвлөгөөг баталсан байна. Ойн хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Тус тушаалын хүрээнд байгууллага ойн арга хэмжээтэй холбоотой дараах зардлуудыг гаргасан байна.

#### Ойн арга хэмжээний зардлын жагсаалт

Хүснэгт 2 /мянган төгрөг/

№	Тушаалын			Зардлын утга	Гүйцэтгэл	Зөрүү
	Огноо	Дугаар	Мөнгөн дүн			
1	2024.09.05	А/37	15,070.0	Ойн тэмцээний нэгдсэн заавар, медалийн зардал	15,070.0	-
2	2024.09.17	А/40	18,200.0	Ойн хүндэтгэлийн гарын бэлэг худалдан авах зардал	21,525.0	-3,325.0
3	2024.09.17	А/41	19,800.0	Түүхэн ном хийх зардал	19,500.0	300.0
4	2024.10.15	А/45	3,830.0	Үндэсний бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээний зардал	3,378.0	452.0
5	2024.10.15	А/46	2,520.0	Байгууллагын аварга шалгаруулах 6 төрөлт тэмцээний зардал	2,520.0	-
6	2024.10.15	А/47	2,592.0	Тэмцээний өргөмжлөл хийлгэх зардал	2,457.0	135.0
7	2024.10.15	А/48	15,220.0	Сагсан бөмбөгийн тэмцээний зардал	14,650.0	570.0
8	2024.10.15	А/49	3,860.0	Дархан марафоны зардал	3,860.0	-
9	2024.10.25	А/52	8,000.0	Волейболын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээний зардал	8,000.0	-
10	2024.10.29	А/53	19,330.0	Үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн зардал	11,664.0	7,666.0

11	2024.11.13	A/54	4,651.0	Ахмадын спортын наадмын зардал	4,651.0	-
Нийт дүн			113,073.00		107,275.00	5,798.00

Дээрх тушаалаарх зардлаас гадна ойн хүрээнд байгууллагын их заалны зааланд завсар хийсэн байна. Тус урсгал засварыг 2 иргэнтэй 9,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ба зардлыг үндсэн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлсэн байна. Гэрээгээр их заалны таазны хөмсөг рейк хийх, их заалны шалыг сэргээн будах ажил хийгдсэн байна. Засвартай холбоотой засварын материалын 17,367.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч зарцуулжээ.

Ойн хүрээнд нийт 134,142.0 мянган төгрөгийн зардал зарцуулагдсан ба үүнд түүхэн ном бүтээхэд 19,500.0 мянган төгрөг, тэмцээн уралдааны зардалд 66,250.0 мянган төгрөг, засварт 26,867.0 мянган төгрөг, гарын бэлгэнд 21,525.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **2.2.2 Ойн хандив тусламжийн зарцуулалт**

Ойн арга хэмжээний төлөвлөгөөт ажил болох Сагсан бөмбөгийн насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнд Банкуудын холбооноос 11,000.0 мянган төгрөгийн шагналын сангийн зардлыг санхүүжүүлжээ. Тус санхүүжитийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100190034410 дугаар харилцах дансаар хүлээн авч шагналыг тэмцээний протоколыг үндэслэж шагнал авсан тамирчдад олгож санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн санхүүгийн тайланд тусган тайлагнажээ.

Мөн Дархан төмөрлөгийн үйлдвэр-15,445.0 мянган төгрөг, Дархан сумын ЗДТГ-17,065.4 мянган төгрөгөөр тус байгууллагын цайны газар, ариун цэврийн өрөөг засварлаж өгсөн байна. Тус засварыг санхүүгийн тайланд 32,510.4 мянган төгрөгийн хандиваар бүртгэж тайлагнажээ.

Дээрх хандиваар хийгдсэн ажлыг байгууллагын Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй.

2.3. Байгууллагын удирдлага нь улсын төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд өөрийн хамаарал бүхий этгээдийн хамт гадаад улсад албан томилолтоор ажилласан тухай:

Тус байгууллага нь төрийн сангийн 3 данстай байна. Улсын төсвийн санхүүжилтийн 100190034010, орон нутгийн санхүүжилтийн 100190035009, нэмэлт санхүүжилтийн 100190034410 дугаар харилцах данснуудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж байна.

Тус байгууллагын батлагдсан төсөвт 2024-2025 оны батлагдсан төсөвт гадаад албан томилолтын зардал тусгагдаагүй ба зөвхөн дотоод албан томилолт тусгагдсан байна.

Дээрх төрийн сангийн харилцах дансны гүйлгээ шалгахад гадаад томилолттой холбоотой гүйлгээ байхгүй, харин дотоод албан томилолт дараах байдалтай. Үүнд:

Дотоод томилолт

Хүснэгт 3 /мянган төгрөг/

№	Он	Төсөв	Гүйцэтгэл	Тайлбар	Хаана
1	2024	2,452.4	1,330.9	5 албан хаагч	Улаанбаатар
2	2025	739.2	739.1	4 албан хаагч	Орхон, Улаанбаатар

Дотоод томилолт авсан албан хаагчдын жагсаалт

Хүснэгт 4 /төгрөгөөр/

№	Албан хаагчдийн нэрс	Мөнгөн дүн	Удаа	Томилолтын зорилго
<b>2024 он</b>				
1	Ё.Батдархан	342.0	1	Чөлөөт бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн /Улаанбаатар хот луу/
2	А.Амраа	50.0	1	Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн оролцох /Улаанбаатар хот луу/
3	Х.Батбаяр	498.9	3	Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, Байгууллагын ойн бэлтгэл ажил, Үндэсний олимпын хорооны хурал оролцох
4	Д. Балжинням	240.0	1	Жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн /Улаанбаатар хот луу/
5	Г.Төгсбаяр	200.0	1	Кик боксын улсын аварга шалгаруулах тэмцээн /Улаанбаатар хот луу/
		1,330.9		
<b>2025 он</b>				
1	С. Сүхбаатар	50.0	1	Хүүхдийн спортын 8-р их наадам /Орхон аймаг/
2	Х.Батбаяр	154.0	2	Хүүхдийн спортын 8-р их наадам /Орхон аймаг/, хяналт үнэлгээний албан хаагчдын мэргэшүүлэх сургалт /Улаанбаатар хот/
3	Б. Мөнхчимэг	50.0	1	Хүүхдийн спортын 8-р их наадам /Орхон аймаг/
4	Г.Төгсбаяр	484.0	1	Боксын улсын аварга шалгаруулах тэмцээн /Улаанбаатар хот луу/
		739.1		

Байгууллагын хэмжээнд дотоод албан томилолтыг батлагдсан төсөвт багтаан томилолтын зардлыг олгожээ. Тус олгогдсон албан томилолт нь Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг

шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу бүрэн олгогдоогүй буюу хоолны зардлыг ихэвчлэн олгожээ.

Тус гомдолд дурдсан “Байгууллагын удирдлага нь улсын төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд өөрийн хамаарал бүхий этгээдийн хамт гадаад улсад албан томилолтоор ажилласан” гэсний дагуу байгууллагын дарга А.Амараагийн хувийн дансанд улсын болон орон нутгийн, нэмэлт орлогын харилцах данснаас шилжүүлсэн гүйлгээ байгаа эсэхийг хянахад түүний цалин хөлснөөс гадна 2024 онд албан томилолтоор ажилласан 50.0 мянган төгрөг нэг удаагийн томилолтын зардал орсноос өөр гүйлгээ хийгдээгүй байна.

Байгууллагын дарга А.Амраагаас бичгээр тодруулга авахад: *“Гэр бүлийн хамт сүүлийн 2 жил Бүгд Найрамдах Турк улс, Арабын Нэгдсэн Эмират улсын Дубай хотод хувийн зардлаараа аяллын компаниар дамжуулан аялсан гэр бүлийн орлогоосоо аяллын зардлыг санхүүжүүлсэн. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Жүдо бөхийн холбооны урилгаар Дархан-Уул аймгийн Засаг даргын хамт тус улсад 2025 оны 10 дугаар сарын 22-29-ний хооронд туршлага судалж ажилласан ба холбогдох зардлыг нөгөө талаас хариуцан гаргасан ба байгууллагаас зардал гаргаагүй болно.”* гэсэн тайлбар өгсөн.

#### ГУРАВ.ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫГ ТАЛААР

**1.Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг баримталж шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж ур чадварын нэмэгдлийг олгохгүй байна.**

Тус байгууллагын 2025 оны цалин хөлс, нэмэгдэл цалинг шалгахад 1-12 сард нийт 27 албан хаагчаас 12-14 ажилтан, албан хаагчдад 25 хувиар ур чадварын нэмэгдлийг олгожээ. Ур чадварын нэмэгдлийг олгохдоо улирал бүр байгууллагын даргын тушаалаар олгож байгаа боловч ур чадварын нэмэгдлийг олгох журамд заасан ажил мэргэжлийн онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг батлаагүй, нийт албан хаагчдыг нийтлэг журмын дагуу үнэлсэн үнэлгээ, албан хаагчдын тайлан, хурлаар хэрэлцүүлсэн баримт зэрэг холбогдох баримт, материал байхгүй байна. Тус асуудлаар зөвлөмж хүргүүлж байна.

**2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 дахь заалт “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”-ыг хориглосон заалтыг мөрдөөгүй байна.**

Байгууллагын даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны А/40 дүгээр “Зардал гаргах тухай” тушаалаар Ойн хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох зочдод өгөх 18,200.0 мянган төгрөгийн гарын бэлгийн зардлыг баталжээ. Санхүүгийн анхан шатны

баримтыг шалгахад нийт 21,525.0 мянган төгрөгийн гарын бэлэгт зарцуулжээ. Үүнд:Ти Энд Ти ХХК-аас 18,200.0 мянган төгрөгийн тэмдэглэлийн дэвтэр, бал, усны сав бүхий бэлгийн багц, Есөн-Од ХХК-аас 3,000.0 мянган төгрөгөөр байгууллагын лого бүхий амттаны цуглуулгыг худалдан авчээ. Тус зардал нь Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэж байна.

**3. Шилэн дансны тухай хуулийн 6.3.5 дахь заалт “хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт” Сангийн сайдын 2016 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.2.1.12 дахь заалт “Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан; 3.2.7 дахь заалт “Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын байгууллагын 60 ойн арга хэмжээний төлөвлөгөөт ажил болох Сагсан бөмбөгийн насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээний шагналын сангийн 11,000.0 мянган төгрөгийн хандив, Дархан төмөрлөгийн үйлдвэр-15,445.0 мянган төгрөгийн цайны газрын засвар, Дархан сумын ЗДТГ-17,065.4 мянган төгрөгийн байгууллагын ариун цэврийн өрөөний засвар зэрэг нийт 43,510.4 мянган төгрөгийн хандивын талаарх мэдээллийг Шилэн дансны цахим хуудасны Төсөв гүйцэтгэл цэсийн Хандив тусламжийн орлого хэсэгт мэдээлээгүй байна. Иймд тус зөрчилд албан шаарлага хүрүүлхээр шийдвэрлэж байна.

**4. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Ил тод байдлыг хангасан байх” зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Байгууллагын 60 ойн үйл ажиллагаатай холбоотой хийгдсэн арга хэмжээ талаарх үйл ажиллагааны үр дүн болон төсөв санхүүгийн зарцуулалтыг байгууллага ажилтан, албан хаагчдад болон бусад хэрэглэгчдэд нээлттэй мэдээлж тайлагнаагүй.

## **ДҮГНЭЛТ**

Удирдамжийн хүрээнд Дархан-Уул аймгийн биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдын 2025 оны цалингийн сангийн зарцуулалт, ажлын цаг ашиглалтын талаар хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, байгууллагын 2024 онд тохиосон ойн арга хэмжээний төсөв, хандив тусламжийн хөрөнгийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, Байгууллагын удирдлага нь улсын төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд өөрийн хамаарал бүхий этгээдийн хамт гадаад улсад албан томилолтоор ажилласан нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Тус байгууллага 2025 оны жилийн эцсийн байдлаар 28 орон тоонд 949,132.2 мянган төгрөгийн цалин олгогдсоноос улсын төсвийн санхүүжилтээр 793,469.4 мянган төгрөгийн цалин хөлс болон нэмэгдэл цалин, орон нутгийн санхүүжилтээр 155,662.8 мянган төгрөгийн орон

нутагт ажилласны нэмэгдлийг тухай бүр олгосон буюу шалгалтаар илэрсэн асуудлаас бусад цалин, нэмэгдлийг холбогдох хууль журамд заасны дагуу олгосон нь санхүүгийн анхан шатны баримтаар нотлогдож байгаа тул хууль тогтоомжид нийцэж байна.

2. Байгууллагын ойн арга хэмжээнд нийт 134,142.0 мянган төгрөг төсөв зарцуулагдсанаас 11,000.0 мянган төгрөгийг хандиваар санхүүжүүлж тэмцээний шагналын санд зарцуулсан. Мөн 32,510.4 мянган төгрөгийн засвар үйлчилгээг хандиваар бүртгэж санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан боловч Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй нь хууль тогтоомжид нийцэхгүй байна;
3. Тус байгууллагын төсөвт гадаад томилолтын төсөв байхгүй, дотоод албан томилолт 2024 онд 1,330.90 мянган төгрөгийг 5 албан хаагчид, 2025 онд 739.1 мянган төгрөгийг 4 албан хаагчид тус тус олгожээ. Мөн байгууллагын харилцах данснаас байгууллагын дарга А.Амараа луу 2024 онд томилолтын зардалд нэг удаа 50.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэнээс өөр зардал шилжүүлсэн гүйлгээ байхгүй байгаа нь хууль тогтоомжид нийцэж байна.
4. Шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилд 3 заалт бүхий санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн албан шаардлага тогтоож байна.

#### ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахыг Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга А.Амараа, нягтлан бодогч Б.Мөнхчимэг нарт даалгаж байна. Үүнд:

1. Байгууллагын нийт албан хаагчдыг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албанхаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг нийцүүлэн шалгуур үзүүлэлтийг тогтоон үнэлж, албан хаагчдад танилцуулан, ур чадварыг нэмэгдлийг тохирсон хувь хэмжээгээр олгох.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон болон хязгаарласан зардлыг гаргахгүй байх Төсвийн тухай хуулийн 5.1.3. дахь заалт “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” ажиллах;

3. Шилэн дансны хууль, журмыг хэрэгжилтийг хангаж хуулиар ил тод нээлттэй мэдээллэх мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах;

4. Байгууллагын хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд байгууллага хамт болон бусад хэрэглэгчдэд нээлттэй мэдээлж Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Ил тод байдлыг хангасан байх” зарчмыг хэрэгжүүлж ажиллах;

5. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo--